



МОНГОЛД ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ ТУХАЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Энэ сарын 23-нд Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Солонгосын Хадгаламжийн Даатгалын Корпорацийн хооронд манай улсад хадгаламжийн даатгалын систем нэвтрүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Уулзалтад манай талаас Сангийн дэд сайд Ч.Ганхуяг, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан, Солонгосын талаас Хадгаламжийн Даатгалын Корпорацийн захирал И Сын Ү нар байлцав.

Энэ удаагийн харилцан ойлголцлын санамж бичиг нь манай улсад хадгаламжийн даатгалын систем нэвтрүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан дээрх гурван байгууллагын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Уг санамж бичиг байгуулагдсанаар БНСУ-ын Хадгаламжийн Даатгалын Корпорациас манай улсад хадгаламжийн даатгалын байгууллага байгуулах бодлогын зөвлөгөө (**Technical Assistance**) болон хадгаламжийн даатгалын системийн үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах боловсон хүчнийг бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Фото сурвалжлага







МОНГОЛБАНК